



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/31/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Архангай аймаг  
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх  
аудитор: Т.Байгалмаа  
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар  
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Алтанчимэг  
Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан / .....	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
<b>3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....</b>	<b>17</b>
3.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	18
Аудитын илрүүлэлт .....	18
4.2 Албан шаардлага .....	18
4.3 Зөвлөмж .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

## 1. Аудитын санал дүгнэлт



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.28 № 91  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  
Р.ГАНДИЙМАА ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>159,529,840.34</b>	<b>326,594,234.05</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>18,489.76</b>	<b>18,489.76</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>18,489.76</b>	<b>18,489.76</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>18,489.76</b>	<b>18,489.76</b>
31211	Төрийн сангийн харилцах	18,489.76	18,489.76
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>7,931,697.00</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	5,000,000.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>0.00</b>	<b>2,931,697.00</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	2,931,697.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>159,511,350.58</b>	<b>318,644,047.29</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>121,246,515.68</b>	<b>269,945,182.39</b>
35130	Эм боох материал	121,246,515.68	269,945,182.39
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>30,009,834.90</b>	<b>38,408,864.90</b>
35410	Бичиг хэргийн материал	722,140.00	966,540.00
35420	Аж ахуйн материал	26,051,200.00	34,046,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,085,050.00	308,700.00
35440	Түлш, шатах тослох материал	641,844.90	2,609,024.90
35450	Барилгын засварын материал	509,600.00	478,000.00
35600	Мал амьтад	8,255,000.00	10,290,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,007,765,967.29</b>	<b>983,363,971.77</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,007,765,967.29</b>	<b>983,363,971.77</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>977,442,217.29</b>	<b>953,208,971.77</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,011,081,800.00	1,011,081,800.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-175,480,666.32	-187,376,891.25
39203	Авто-тээврийн хэрэгсэл	165,100,000.00	158,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-91,233,333.22	-99,687,499.89
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	171,431,418.36	170,085,648.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-121,008,103.09	-112,199,078.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,939,983.00	45,943,048.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,388,881.44	-33,538,054.74
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>30,323,750.00</b>	<b>30,155,000.00</b>
39301	Програм хангамж	960,000.00	960,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-636,250.00	-805,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,167,295,807.63</b>	<b>1,309,958,205.82</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,167,295,807.63</b>	<b>1,309,958,205.82</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,167,295,807.63</b>	<b>1,309,958,205.82</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	354,676,983.74	354,676,983.74
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>795,011,236.59</b>	<b>955,000,516.28</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	743,333,539.79	812,338,118.09
51220	Тайлант үеийн үр дүн	51,677,696.80	142,662,398.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,607,587.30	280,705.80
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,167,295,807.63</b>	<b>1,309,958,205.82</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,709,891,367.60</b>	<b>10,996,009,240.56</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>479,829,547.60</b>	<b>7,009,823,551.56</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>479,829,547.60</b>	<b>7,009,823,551.56</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	20,328,367.00	49,085,257.55
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	459,501,180.60	6,960,738,294.01
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,230,061,820.00</b>	<b>3,986,185,689.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,095,555,200.00</b>	<b>2,430,821,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,095,555,200.00	2,430,821,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>134,506,620.00</b>	<b>1,555,363,889.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	45,969,420.00	166,563,089.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	9,087,850.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,537,200.00	1,379,712,950.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,322,423,646.78</b>	<b>4,105,462,391.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,322,423,646.78</b>	<b>4,105,462,391.93</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,359,725,212.23</b>	<b>1,180,623,275.29</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>574,180,900.00</b>	<b>586,374,999.00</b>
210101	Үндсэн цалин	334,280,354.00	327,601,912.00
210102	Нэмэгдэл	155,698,203.00	175,270,994.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,005,000.00	35,055,000.00
210104	Урамшуулал	48,197,343.00	48,447,093.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,534,861.04</b>	<b>76,239,504.14</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,323,961.04	54,587,983.56
210202	Тэтгэмжийн даатгал	5,052,700.00	5,624,852.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,359,000.00	4,473,002.44
210204	Ажилгүйдлийн даатгал	1,010,500.00	1,050,332.29
210205	Эрүүл мэндийн даатгал	9,788,700.00	10,503,332.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>60,188,649.28</b>	<b>59,063,347.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,374,245.28	8,039,532.37
210302	Түлш, халаалт	48,321,504.00	48,321,504.00
210303	Цэвэр, бохир ус	2,492,900.00	2,702,310.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>68,625,726.13</b>	<b>63,219,994.09</b>
210401	Бичиг хэрэг	10,970,930.00	8,471,050.00
210402	Тээвэр, шатахуун	48,022,250.00	43,778,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,922,776.13	4,690,504.09
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,515,870.00	4,149,820.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,193,900.00	2,130,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>358,774,507.75</b>	<b>105,226,348.05</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	358,774,507.75	101,015,348.05
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	4,211,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,227,190.00</b>	<b>15,235,850.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	60,000.00
210604	Урсгал засвар	12,227,190.00	15,175,850.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,806,000.00</b>	<b>21,614,418.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,806,000.00	21,614,418.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,772,948.00</b>	<b>7,214,402.06</b>
210803	Даатгалын үйлчилгээ	2,570,000.00	2,570,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	259,748.00	258,780.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	91,800.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,801,400.00	4,159,222.06
210807	Газрын төлбөр	90,000.00	90,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000.00	70,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>190,614,430.03</b>	<b>246,434,412.88</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,437,900.00	183,851,521.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,780,600.00	1,938,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,395,930.03	60,644,431.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>962,698,434.55</b>	<b>2,924,839,116.64</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>948,792,655.00</b>	<b>2,879,534,109.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	570,106,629.00	544,534,949.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	351,868,026.00	998,382,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,818,000.00	1,336,616,560.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13,905,779.55</b>	<b>45,305,007.64</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,905,779.55	45,305,007.64
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>387,467,720.82</b>	<b>6,890,546,848.63</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>335,790,024.02</b>	<b>6,747,884,450.44</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	477,328.56	17,841,621.19
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	335,312,695.46	6,730,042,829.25
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>51,677,696.80</b>	<b>142,662,398.19</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	354,676,983.74	18,913,596.40	742,027,530.69	1,115,618,110.83
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,306,009.10	1,306,009.10
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	354,676,983.74	18,913,596.40	743,333,539.79	1,116,924,119.93
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-1,306,009.10	0.00	-1,306,009.10
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	51,677,696.80	51,677,696.80
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	354,676,983.74	17,607,587.30	795,011,236.59	1,167,295,807.63
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	354,676,983.74	17,607,587.30	795,011,236.59	1,167,295,807.63

12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	17,326,881.50	17,326,881.50
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	354,676,983.74	17,607,587.30	812,338,118.09	1,184,622,689.13
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-17,326,881.50	0.00	-17,326,881.50
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	142,662,398.19	142,662,398.19
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	354,676,983.74	280,705.80	955,000,516.28	1,309,958,205.82

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,230,061,820.00</b>	<b>3,986,185,689.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,230,061,820.00</b>	<b>3,986,185,689.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,095,555,200.00</b>	<b>2,430,821,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,095,555,200.00	2,430,821,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>134,506,620.00</b>	<b>1,555,363,889.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	45,969,420.00	166,563,089.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	9,087,850.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,537,200.00	1,379,712,950.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,225,080,820.00</b>	<b>3,981,186,889.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,225,080,820.00</b>	<b>3,981,186,889.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,262,382,585.45</b>	<b>1,048,416,075.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>574,180,900.00</b>	<b>586,374,999.00</b>
210101	Үндсэн цалин	334,280,354.00	327,601,912.00
210102	Нэмэгдэл	155,698,203.00	175,270,994.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,005,000.00	35,055,000.00
210104	Урамшуулал	48,197,343.00	48,447,093.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,534,861.04</b>	<b>76,239,504.14</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,323,961.04	54,587,983.56
210202	Тэтгэмжийн даатгал	5,052,700.00	5,624,852.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,359,000.00	4,473,002.44
210204	Ажилгүйдлийн даатгал	1,010,500.00	1,050,332.29
210205	Эрүүл мэндийн даатгал	9,788,700.00	10,503,332.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>60,188,649.28</b>	<b>59,063,347.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,374,245.28	8,039,532.37
210302	Түлш, халаалт	48,321,504.00	48,321,504.00
210303	Цэвэр, бохир ус	2,492,900.00	2,702,310.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>68,925,186.13</b>	<b>57,240,408.41</b>
210401	Бичиг хэрэг	10,173,150.00	8,674,750.00
210402	Тээвэр, шатахуун	44,885,300.00	37,925,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,578,776.13	4,388,658.41
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,792,060.00	4,252,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,495,900.00	1,998,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>331,580,761.00</b>	<b>24,450,910.00</b>

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	331,580,761.00	23,470,910.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	980,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,299,290.00</b>	<b>16,686,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	385,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,130,000.00	2,852,000.00
210604	Урсгал засвар	13,169,290.00	13,449,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,806,000.00</b>	<b>21,614,418.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,806,000.00	21,614,418.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,166,448.00</b>	<b>8,146,247.74</b>
210803	Даатгалын үйлчилгээ	2,570,000.00	2,570,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	259,748.00	258,780.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	91,800.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,194,900.00	5,091,067.74
210807	Газрын төлбөр	90,000.00	90,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000.00	70,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>116,700,490.00</b>	<b>198,599,841.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	113,919,890.00	196,661,381.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,780,600.00	1,938,460.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>962,698,234.55</b>	<b>2,932,770,813.64</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>948,792,455.00</b>	<b>2,882,465,806.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	570,106,629.00	547,466,646.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	351,868,026.00	998,382,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,817,800.00	1,336,616,560.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13,905,779.55</b>	<b>50,305,007.64</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,905,779.55	50,305,007.64
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>4,981,000.00</b>	<b>4,998,800.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>4,981,000.00</b>	<b>4,998,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,981,000.00</b>	<b>4,998,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,981,000.00</b>	<b>4,998,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,981,000.00	4,998,800.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-4,981,000.00</b>	<b>-4,998,800.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,489.76	18,489.76
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,489.76	18,489.76

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,430,821,800.00</b>	<b>2,385,516,792.36</b>	45,305,007.64	98.1

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,430,821,800.00</b>	<b>2,385,516,792.36</b>	45,305,007.64	98.1
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>858,121,300.00</b>	<b>832,650,986.36</b>	25,470,313.64	97.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>578,278,400.00</b>	<b>559,655,929.00</b>	18,622,471.00	96.8
210101	Үндсэн цалин	336,037,400.00	327,601,912.00	8,435,488.00	97.5
210102	Нэмэгдэл	157,080,400.00	148,551,924.00	8,528,476.00	94.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,355,000.00	35,055,000.00	300,000.00	99.2
210104	Урамшуулал	49,805,600.00	48,447,093.00	1,358,507.00	97.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>76,420,600.00</b>	<b>72,176,774.14</b>	4,243,825.86	94.4
210201	Тэтгэврийн даатгал	53,777,400.00	50,525,253.56	3,252,146.44	94.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,660,800.00	5,624,852.89	35,947.11	99.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,528,600.00	4,473,002.44	55,597.56	98.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,132,200.00	1,050,332.29	81,867.71	92.8
210205	Эрүүл мэндийн даатгал	11,321,600.00	10,503,332.96	818,267.04	92.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>61,611,000.00</b>	<b>59,063,347.07</b>	2,547,652.93	95.9
210301	Гэрэл, цахилгаан	10,370,000.00	8,039,532.37	2,330,467.63	77.5
210302	Түлш, халаалт	48,428,500.00	48,321,504.00	106,996.00	99.8
210303	Цэвэр, бохир ус	2,812,500.00	2,702,310.70	110,189.30	96.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,971,200.00</b>	<b>50,968,408.41</b>	2,791.59	100.0
210401	Бичиг хэрэг	8,674,800.00	8,674,750.00	50.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	32,026,300.00	31,653,400.00	372,900.00	98.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,017,100.00	4,388,658.41	-371,558.41	109.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,253,000.00	4,252,700.00	300.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,998,900.00	1,100.00	99.9
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15,372,400.00</b>	<b>15,363,060.00</b>	9,340.00	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,392,300.00	14,383,060.00	9,240.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	980,100.00	980,000.00	100.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,886,400.00</b>	<b>17,885,400.00</b>	1,000.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,584,000.00	1,584,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,853,000.00	2,852,000.00	1,000.00	100.0
210604	Урсгал засвар	13,449,400.00	13,449,400.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>20,382,800.00</b>	<b>20,360,500.00</b>	22,300.00	99.9
210702	Дотоод албан томилолт	20,382,800.00	20,360,500.00	22,300.00	99.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,956,300.00</b>	<b>11,946,047.74</b>	10,252.26	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	2,570,000.00	2,570,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	260,000.00	258,780.00	1,220.00	99.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,899,900.00	8,890,867.74	9,032.26	99.9
210807	Газрын төлбөр	90,000.00	90,000.00	0.00	100.0

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	70,400.00	70,400.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,242,200.00</b>	<b>25,231,520.00</b>	10,680.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,303,200.00	23,293,060.00	10,140.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,939,000.00	1,938,460.00	540.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,572,700,500.00</b>	<b>1,552,865,806.00</b>	19,834,694.00	98.7
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,572,700,500.00</b>	<b>1,552,865,806.00</b>	19,834,694.00	98.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	558,996,000.00	547,466,646.00	11,529,354.00	97.9
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,006,684,500.00	998,382,600.00	8,301,900.00	99.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,020,000.00	7,016,560.00	3,440.00	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,430,821,800.00</b>	<b>2,385,516,792.36</b>	45,305,007.64	98.1
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,430,821,800.00</b>	<b>2,385,516,792.36</b>	45,305,007.64	98.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,430,821,800.00	2,385,516,792.36	45,305,007.64	98.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	18,489.76	-18,489.76	#DIV/0!
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	18,489.76	-18,489.76	#DIV/0!
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>83.00</b>	<b>73.00</b>	10.00	88.0
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>41.00</b>	<b>36.00</b>	5.00	87.8
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	24.00	5.00	82.8
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	0.00	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>41.00</b>	<b>36.00</b>	5.00	87.8
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	14.00	12.00	2.00	85.7
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	14.00	12.00	2.00	85.7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	12.00	1.00	92.3

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,550,363,889.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,550,363,889.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	220,763,889.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	26,719,070.00
210102	Нэмэгдэл	26,719,070.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,062,730.00
210201	Тэтгэврийн даатгал	4,062,730.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,272,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,272,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	9,087,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,087,850.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,253,918.00
210702	Дотоод албан томилолт	1,253,918.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	173368321.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	173,368,321.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1329600000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,329,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,329,600,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1555363889.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,555,363,889.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	166,563,089.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,087,850.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,379,712,950.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 12 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Эрүүл мэндийн газар нь тайлант жилд Үр дүнтэй манлайлал бүхий хамт олныг бүрдүүлэн байгууллагын хөгжлийг хангаж харьяа нутгийн хүн амд эрүүл мэндийн ээлтэй чанартай цогц тусламж үйлчилгээг үзүүлэх замаар орон нутгийн хөгжил амьдралын чанарыг сайжруулах зорилготой үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тайлант жилд Байгууллагын болон орон нутгийн хөгжил, амьдралын чанарт дэвшил гаргах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн хэдий ч дотоод аудитын илрүүлэлтийг аудитын үйл ажиллагаанд ашигласан болно.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Эрүүл мэндийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 2,430.8 сая төгрөгөөс 1%-иар буюу 24.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 %-иар буюу буюу 17.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 142.6 сая төгрөгөөр буюу 12%-иар өссөн байна. Оны эхний үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Мөнгөн хөрөнгө	0.01	0.01	-	-
Бараа материал	159.5	318.6	159.1	1.00
Авлага		7.9	7.9	#DIV/0!
Үндсэн хөрөнгө	1,007.8	983.4	(24.4)	-0.02
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,167.3</b>	<b>1,309.9</b>	142.6	0.12
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,167.3	1,309.9	142.6	0.12
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,167.3</b>	<b>1,309.9</b>	142.6	0.12

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- *Бараа материал эхний үлдэгдлээс 1 дахин өссөн байна.*

Бараа материалын данс нь 159.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 100.1 сая төгрөг, хандив тусламжаар ирсэн 6,960.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 6,901.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 318.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Авлагын данс 7.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 7.9 сая төгрөгийн авлага тайлагнагдсан нь татаас санхүүжилтийн авлага буюу ЭМЯ-аас авах 5.0 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага буюу 2.9 сая төгрөг байна

- *Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 0.02 хувиар буурсан байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 1,007.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 5.0 сая төгрөгийн хөрөнгө, хандив тусламжаар 51.2 сая төгрөгийн хөрөнгө нийт 54.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 80.6 сая элэгдлийн болон акталж устгасны зардлаар буурч 983.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой бөгөөд тайлант хугацаанд 142.6 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

## Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх	Тайлант	Зөрүү
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,676.1</b>	<b>10,996.0</b>	8,319.9
2	Үнэ төлбөргүй ирсэн орлого	446.1	7,009.8	
3	Төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс авсан хандив	46.0	166.6	120.6
4	ЗГНХ, ЗДНХ-түүнтэй адилтгах хөрөнгө		9.1	9.1
5	Дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан хөрөнгө	88.5	1,379.7	1,291.2
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,095.5	2,430.8	335.3
7	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,301.7</b>	<b>4105.2</b>	1,803.5
8	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,339.0	1,180.4	(158.6)
9	Урсгал шилжүүлэг	962.7	2,924.8	1,962.1
10	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.5	17.8	17.3

11	Үнэ төлбөргүй гарсан зардал	336.1	6,730.0	6,393.9
12	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>37.8</b>	<b>143.0</b>	105.2

Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны орлого өмнөх оноос 8,319.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант жилд ковид-19 цар тахал гарч ЭМЯ-аас үнэ төлбөргүй ирсэн вакцин урамшуулал зэргээс шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 2,529.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 98.4 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 2,430.8 сая төгрөгөөр хянаж баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2,430.8 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,430.8 сая төгрөгийн санхүүжилт авч 2,385.5 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 45.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний зардлаас 25.4 сая төгрөг, урсгал шилжүүлгээс 19.8 сая төгрөгийг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 1,555.3 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс 166.6 сая төгрөг

- МСЭМХолбооноос сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийн зардалд-1.2 сая төгрөг,
- Ковид урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зардалд-8.5 сая төгрөг,
- Сүрьеэгийн эрт илрүүлэг шинжилгээ, хяналтын зардалд-10.5 сая төгрөг,

- ДЭМБ-аас ковидын хариу арга хэмжээг сайжруулах, тандалтыг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зардалд-134.7 сая төгрөг,
- Ковидын дархлаажуулалтын дэмжлэгт хяналт хийх зардалд-7.9 сая төгрөг,
- АХБ-наас ЭМБ-уудын гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох сургалтын зардалд-3.7 сая төгрөг

Аймгийн засаг даргын нөөц хөрөнгө болон Онцгой комиссоос 9.1 сая төгрөг

- ЭМБ-ын ажилчдын дархлааг дэмжих зорилгоор-8.2 сая төгрөг,
- Эмийн өрийг барагдуулахад дэмжлэг үзүүлэх-0.8 сая төгрөг

Эрүүл мэндийн яамнаас -1,379.7 сая төгрөг

- ЭМС-ын 2021-5-10-ны а/298 тоот тушаалаар эрүүл мэндийн ажилтнуудад олгох мөнгөн тэтгэмж урамшуулалд-1,334.6 сая төгрөг
- ЭМС-ын 2021-04-22 №а/248 тоот тушаалаар илүү цагийн хөлсөнд-30.8 сая төгрөг /ЗӨСТ-10.5 сая төгрөг, ЭМГ-20.3 сая төгрөг/,
- Вакцин тээврийн зардалд-6.3 сая төгрөг,
- ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх сургалтын зардалд-5.0 сая төгрөг,
- Нөхөн дархлаажуулалтын зардалд-7.6 сая төгрөг тус тус ирсэн байна

Нийт санхүүжилтээс ЭМЯ-аас ирсэн 1,334.6 төгрөгийг тэтгэмж урамшууллын зардалд зарцуулсан байна. Анхан шатны баримтаас тулган шалгахад санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан бөгөөд 5.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж авлагын тооцоо үүсгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

1. Тайлант жилд ковид-19 цар тахлын эрчимтэй тархалт, 2 дахь давлагаа эхлэж нийт 12,862 хүн өвдөж, 38 хүн нас барсан байна. Аймгийн хэмжээнд ковидын вакцинжуулалтыг зохион байгуулж нийт 60,632 хүн хамруулсан, эмнэлгийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн 24 тусгай эмнэлэг, 1004 ор нэмж дэлгэн ажиллуулсан байна. Үүнтэй холбоотой ЭМГ болон байгууллагууд өөрийн бололцоогоор шаардлагатай нөөцийн бэлэн байдлыг хангахад анхаарч нийт аймгийн хэмжээнд 5,600.0 сая төгрөгийн хамгаалах хувцас хэрэгсэл, эм урвалж бодис, тоног төхөөрөмжийн хангалтыг хийж ковид-19 цар тахлыг эрсдэл багатай даван туулахад бүхий л бололцоогоо дайчлан, шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажилласан байна.
2. Тайлан жилд ЭМГ-ийн 2020-2021 оны хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн СХАА-наас дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж Дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, Удирдлагаас гаргаж буй шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн ажиллах, сул орон тоог нөхөж ажиллах, хууль тогтоомжид заасны дагуу төрийн албан хаагчийн мөнгөн урамшууллыг олгох, Автомашины нормыг тооцож хэвших зэрэг асуудлуудад зөвлөмж хүргүүлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг 90.1 хувь хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,430.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,385.5 сая төгрөгийг зарцуулж, 98.1 хувийн биелэлттэй.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

Эрүүл мэндийн газар нь тусгай чиг үүргийн байгууллага тул төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ хамааралгүй байна.

Харин бусад судалгааны хувьд дараах байдалтай байна.

1. Автомашин ашиглалтын хувьд: Тус байгууллагад үндсэн үйл ажиллагаанд зориулсан 158.9 сая төгрөгийн 3 автомашинтай бөгөөд жилийн шатахууны 41.6 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардалд 0.7 сая төгрөгийг тус тус зарцуулж үндсэн орон тооны 1 жолоочтой байна.
2. Тайлант жилд ковид-19 цар тахал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газарт иргэн ААНБ-аас олгосон 126.6 сая төгрөгийн бараа материалыг бүртгэлд тусгаж газрын даргын тушаалаар зарцуулсан бол 1.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.
3. Хэвлэл мэдээллийн байгууллагатай жилийн турш ажил үйлчилгээ авах гэрээ байгуулан 4.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Архангай аймгийн Онцгой байдлын газар нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 118 мэдээллээс 105 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин 13 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан нь Шилэн дансны тухай

хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Архангай аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн аудитын байгууллагаас хяналт хийгээгүй байна. Харин аймгийн СХАА-наас шалгалт хийсэн байна. Аудитын шийдвэрийг улирал бүр тайлагнахаар байна.

### **3.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн элэгдлийн хугацаатай холбоотой зөвлөмж хүргүүлснийг ЭМГ-ийн даргын 2021.06.11-ны 02/664 тоот бичгээр биелэлтийг хангуулсан байна. Аудитаар хүргүүлсэн шийдвэрийн дагуу 56.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж, дахин үнэлж бүртгэлд тусган ажилласан байна.

### **3.12 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

1. Батлагдсан орон тоо, цалингийн санд багтаан ажилласан эсэх
2. Автомашины шатахууны зарцуулалтыг нормын дагуу тооцож байгаа эсэх
3. Хууль тогтоомж шийдвэрт заасны дагуу төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгож байгаа эсэх

-----oO-----

## 4. Аудитын илрүүлэлт

### Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 17.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 3.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүллээ.

Залруулагдаагүй 20.8 сая төгрөгийн алдаа нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 24.3 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.2 Албан шаардлага

**4.2.1.** ЭМГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 7.9 сая төгрөгийн авлага тайлагнагдсанаас 2.9 сая төгрөг нь 4 хүний тэтгэвэр, тэтгэмжийг ЭМС-ын ирүүлсэн тушаалаас илүү шилжүүлсэнтэй холбоотой авлага байна. Тус авлагыг тайлангийн дараа үед ЭМГ-ийн нэмэлт санхүүжилтийн дансанд буцаан төвлөрүүлэн ажилласан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн тухай хуулийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

**4.2.2.** Мэдээлэл технологийн зардлаас төсөвт зохицуулалт хийлгүй 3.8 сая төгрөгөөр компьютер тоног төхөөрөмж бэлтгэсэн.

**Шийдвэрлэсэн нь:** Сангийн сайдын 2018 оны 134-р тушаал “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

**4.2.3** Бараа материалын тайлан дахь мал амьтдын бүртгэлд 47 тооны эр хонь, 28 тооны эр төлөг, 30 тооны эм төлөг, 147 тооны эм төлөг, 39 тооны эм хонь, 60 тооны хурга нийт 351 тооны 10.9 сая төгрөгийн мал амьтад тоологдсон байна. Малын данс бүртгэлд дэх үнийг судлахад эр хонь 40.0 мянга, эм хонь 35.0 мянга, төлөг 25.0 мянга, хурга 10. мянган төгрөг байгаа нь зах зээлийн үнээс хэт доогуур үнэлгээтэй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Мал амьтдын бүртгэлийг үнэн зөв хийж, үнэн зөв дүнгээр бүртгэлд тусгаж, Төсвийн тухай хуулийн 44.1- дэх заалтыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

### 4.3 Зөвлөмж

**4.3.1** Илүү цагийн хөлсийг олгохдоо ЗГ-ын 382-р тушаалын 2-р хавсралтад заасан үндэслэлээр тооцож олгосон хэдий ч орон тооны сахиулд тус тушаалын 4.1-д заасан үндэслэлээр илүү цаг тооцож олгосон нь ажил үүргийн хуваариас харахад үндэслэл муутай байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү цагийг тооцож олгохдоо ЗГ-ын 382-р тушаалд заасан үндэслэлийг мөрдөж, ажлын гүйцэтгэлийг бодитоор үнэлж, холбогдох нотлох баримтыг бүрэн бүрдүүлж ажиллах зөвлөмж хүргүүллээ.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Эрүүл мэндийн газар	4	20.8					3	17.0	1	3.8
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Эрүүл мэндийн газар	1								1	
<b>НИЙТ ДҮН</b>		<b>5</b>	<b>20.8</b>					<b>3</b>	<b>17.0</b>	<b>2</b>	<b>3.8</b>